

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2013 ОНЫ
2 ДУГААР УЛИРЛЫН ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ
МЭДЭЭ, САНХҮҮГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2013.09.05

Улаанбаатар хот

НЭГ. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭНИЙ ИРЦ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.1 дэх заалтыг үндэслэн “Валютын арилжааг цэгцтэй болгох зорилгоор зарим тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 02 дугаар сарын 28 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-д 7 заалт бүхий 2.6 дахь хэсгийг болон гадаад валютын арилжааны мэдээ гаргах хавсралтуудыг тус тус шинээр нэмж, “Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа” эрхлэн явуулдаг банк бус санхүүгийн байгууллага /цаашид ББСБ гэх/-ууд эдгээр хавсралтын дагуу мэдээг дараа сарын 10-ны өдрийн дотор гаргаж, Хороонд ирүүлж байхыг заасан. Үүний дагуу гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудаас гадаад валютын арилжааны мэдээг сар бүр гаргуулан авч, улирлаар нэгтгэн Хорооны удирдлагуудад танилцуулж, нэгтгэлийг товч байдлаар Монголбанкинд хүргүүлж байгаа болно.

Манай улсын хэмжээнд 2013 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэн явуулж буй 233 ББСБ байгаагийн 98 ББСБ нь буюу нийт ББСБ-ын 42.06 хувь нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

Үүнээс 39 ББСБ нь зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа бөгөөд нийт 233 ББСБ-ын 16.73 хувийг эзэлж, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 98 ББСБ-ын 39.79 хувийг эзэлж байна.

Харин 59 ББСБ нь энэхүү үйл ажиллагааг банк бус санхүүгийн бусад үйл ажиллагаатай давхар эрхлэх зөвшөөрөлтэй байна.

Тайлант хугацаанд гадаад валютын арилжааны мэдээ ирүүлбэл зохих нийт 98 ББСБ-ын 69 нь ирүүлж, 29 нь ирүүлээгүй бөгөөд мэдээний ирц 70.41 хувьтай байна. /Гадаад валютын арилжааны мэдээний ирцийн талаарх мэдээллийг ББСБ тус бүрээр гаргаж, хавсаргав/.

Мэдээ ирүүлээгүй 29 ББСБ нь тайлант хугацаанд энэхүү үйл ажиллагааг эрхлэн явуулаагүй бөгөөд цаашид явуулна гэсэн тайлбар бүхий албан бичгийг Хороонд ирүүлсэн байна. Иймээс гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 98 ББСБ 100.0 хувь нь мэдээгээ ирүүлсэн гэж үзлээ.

Мэдээний ирцийг өмнөх улирлуудтай харьцуулан үзвэл:

/Хүснэгт 1/

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	Мэдээ ирүүлэх ББСБ-ын тоо	Мэдээ ирүүлсэн ББСБ-ын тоо	Мэдээний ирц	Өсөлт, бууралт хувиар /өмнөх улирлаас /
1	2010 оны 1 дүгээр улирал	112	31	27.67%	0.0%
2	2010 оны 2 дугаар улирал	110	43	39.0%	11.33%
3	2010 оны 3 дугаар улирал	109	48	44.0%	5.0%
4	2010 оны 4 дүгээр улирал	95	71	74.7%	30.7%
5	2011 оны 1 дүгээр улирал	93	73	78.5%	3.8%
6	2011 оны 2 дугаар улирал	98	60	61.2%	-17.3%
7	2011 оны 3 дугаар улирал	96	52	54.2%	-7.0%
8	2011 оны 4 дүгээр улирал	92	67	72.8%	18.6%
9	2012 оны 1 дүгээр улирал	91	68	74.7%	3.0%
10	2012 оны 2 дугаар улирал	91	66	72.5%	-2.2%
11	2012 оны 3 дугаар улирал	91	61	67.0%	-5.5%
12	2012 оны 4 дүгээр улирал	94	68	72.3%	5.3%
13	2013 оны 1 дүгээр улирал	98	70	71.4%	-0.9%
14	2013 оны 2 дугаар улирал	98	69	70.4%	-1%

Дээрх хүснэгтээс тайлант хугацаанд валютын арилжааны мэдээний ирцийг хувиар тооцож үзвэл:

- 2010 оны 1,2,3,4 дүгээр улиралд 27.7% -с 74.7%;
- 2011 оны 1,2,3,4 дүгээр улиралд 54.2% -с 78.8%;
- 2012 оны 1,2,3,4 дүгээр улиралд 67.0% -с 74.7%;
- 2013 оны 1 дүгээр улиралд 71.4%;
- 2013 оны 2 дугаар улиралд 70.4% байна.

Тайлант хугацаанд буюу 2013 оны 2 дугаар улиралд нийт 5 ХХК-д ааиё аоñ ñаíð¿¿аёеí ¿ёё аæеёаааа үдөёүд ооñаае ç°аæ°°ð°ё îëâñíоос 1 ББСБ-д нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 98 ББСБ байгаа нь өмнөх улиралтай харьцуулахад өөрчлөгдөөгүй байна. Энэ нь:

- Хорооны 2013 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 202 дугаар тогтоолоор “Эйссосошиэйтс” ХХК-а сээл, аааааа ааёроуи адёёæаа, хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх ¿ёё аæеёаааа эрхлэх зөвшөөрчөл олгож,

- Хорооны 2013 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 158 дугаар тогтоолоор “Их мөнгөн завъяа ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотой.

ХОЁР. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖАА БОЛОН ВАЛЮТЫН ХАНШ

ББСБ-уудаас ирүүлсэн гадаад валютын арилжааны мэдээнд үндэслэн иргэн, хуулийн этгээдээс худалдан авсан гадаад валютууд болон худалдсан гадаад валют тус бүрийн ханшийг ам.доллар болон Монгол улсын үндэсний валют төгрөгт хөрвүүлсэн дүнгээр тус тус тооцон өмнөх улиралтай харьцуулсан байдлаар гаргалаа.

2.1 Гадаад валютыг худалдан авсан болон худалдсан арилжааны талаар:

Тайлант хугацаанд гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх 98 ББСБ-уудын худалдан авсан болон худалдсан валютуудын дүнг ам.доллар, төгрөгт хөрвүүлэн, өмнөх улиралтай харьцуулж үзвэл:


Худалдан авсан /мян.төг/:

/Хүснэгт 2/

№	ВАЛЮТЫН НЭР	Жил		
		2013 оны I дүгээр улирал	2013 оны II дугаар улирал	Өсөлт, бууралт /+;- /өмнөх үеэс/
1	Төгрөгт шилжүүлсэн /мянган төгрөгөөр/	232,589,721.4	198,116,862.8	-34,472,858.6
2	Ам.долларт шилжүүлсэн /мянган ам.доллар/	166,648.2	138,487.1	-28,161.1
3	ДУНДАЖ ХАНШ	1395.69	1430.58	34.89

Худалдан авсан валютуудыг төгрөгт шилжүүлснээр /мян.төг/:

/График1/




Худалдсан /мян.төг/:

/Хүснэгт 3/

№	ВАЛЮТЫН НЭР	Жил		
		2013 оны I дүгээр улирал	2013 оны II дугаар улирал	Өсөлт, бууралт /+;- /өмнөх үеэс/
1	Төгрөгт шилжүүлсэн /мянган төгрөгөөр/	248,997,043.64	188,265,508.26	-60,731,535.38
2	Ам.долларт шилжүүлсэн /мянган ам.доллар/	177,734.34	131,377.48	-46,356.86
3	ДУНДАЖ ХАНШ	1,400.95	1,433.01	32.06

Худалдсан валютуудыг төгрөгт шилжүүлснээр /мян.төг/:

/График 2/




Тайлант улиралд худалдан авсан нийт гадаад валютуудын дүнг төгрөгт хөрвүүлэн, өмнөх улиралтай харьцуулахад 34,472,858.6 мянган төгрөгөөр буюу 14.82 хувиар, ам.долларт хөрвүүлсэн дүнгээр 28,161.1 мянган ам.доллараар буюу 16.89 хувиар буурсан байна. Худалдсан нийт гадаад валютуудын хувьд өмнөх улиралтай харьцуулахад 60,731,535.38 мянган төгрөгөөр буюу 24.39 хувиар, ам.долларт хөрвүүлсэн дүнгээр 46,356.86 мянган ам.доллараар буюу 26.08 хувиар тус тус буурсан байна.

ББСБ-уудын 2013 оны 2 дугаар улиралд худалдаж авсан нийт гадаад валют болон худалдсан нийт гадаад валютуудын дүнг төгрөгт шилжүүлснээр /198,116,862.8₮-188,265,508.26₮/ 9,851,354.6 мянган төгрөг буюу нийт худалдаж авсан үнийн дүнгийн 4.97 хувийг, ам.долларт хөрвүүлснээр /138,487.1\$-131,377.48\$/ 7,109.62 мянган ам.доллар буюу 5.13 хувийг тус тус эзэлж байна. Өөрөөр хэлбэл, тайлант хугацаанд ББСБ-уудаас валютын зах зээлд нийлүүлэх гадаад валютын нийлүүлэлтийн хэмжээ буурсан байна.

Нэгтгэлийн дүнгээр худалдан авсан нийт валютын 14.33 хувийг хуулийн этгээдээс, 85.67 хувийг иргэдээс худалдан авсан, худалдсан нийт валютын 13.43 хувийг хуулийн этгээдэд, 86.57 хувийг иргэдэд худалдсан байх ба энэ нь ББСБ-уудын гадаад валютын арилжаанд ихэвчлэн иргэд үйлчлүүж байгаа болохыг харуулж байна. Гэсэн хэдий ч өмнөх улиралтай харьцуулахад хуулийн этгээдээс гадаад валютыг худалдан авсан дүн 10 хувиар, хуулийн этгээдэд гадаад валютыг худалдсан дүн 10.1 хувиар тус тус өссөн дүнтэй байна.


Хуулийн этгээдээс худалдан авсан валютуудын дүн:

/График 3/




Хуулийн этгээдэд худалдсан валютуудын дүн:

/График 4/




Иргэдээс худалдан авсан валютуудын дүн:

/График 5/



Иргэдэд худалдсан валютуудын дүн:

/График 6/




2.2 Валютын ханшны талаар:

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх 98 ББСБ-ын худалдан авсан болон худалдсан нийт валют тус бүрийн дундаж ханшийг харуулбал:


Гадаад валютуудыг худалдан авсан дундаж ханш:

/График 7/



Гадаад валютуудыг худалдсан дундаж ханш:

/График 8/



ББСБ-уудын худалдан авсан нийт гадаад валют тус бүрийн ханшийг ам.долларт хөрвүүлсэн дүнгээр тооцож, дундаж ханшийг тооцож үзэхэд 1,430.58 төгрөг болж байгаа нь дундаж ханш өмнөх

улирлаас /1,395.69₮:1,430.58₮/ 34.89 төгрөгөөр буюу 2.49 хувиар, худалдсан валютын хувьд 1,433.01 төгрөг байгаа нь /1,400.95₮:1,433.01₮/ 32.06 төгрөгөөр буюу 2.28 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

ББСБ-уудын гадаад валютын арилжаанд түгээмэл ордог гадаад валютуудын зах зээл дэх ханшийн өөрчлөлт /хэлбэлзэл/-ийг 2013 оны 1 дүгээр улирал, 2013 оны 2 дугаар улирлын байдлаар харьцуулбал:

/Төгрөгөөр/


/Хүснэгт 4/

№	Валютын төрөл		Худалдаж авсан дундаж ханш			Худалдсан дундаж ханш		
			2013 оны I улирал	2013 оны II улирал	Өсөлт, бууралт /+;- / <i>өмнөх үеэс</i> /	2013 оны I улирал	2013 оны II улирал	Өсөлт, бууралт /+;- / <i>өмнөх үеэс</i> /
1	АНУ доллар	USD	1,395.69	1,430.58	34.89	1,400.95	1,433.01	32.06
2	Английн фунт	GBP	2,173.11	2,193.87	20.76	2,188.21	2,216.82	28.61
3	Евро	EUR	1,823.52	1,864.37	40.85	1,849.73	1,880.27	30.54
4	БНХАУ-ын юань	CNY	223.83	232.30	8.47	225.38	234.15	8.77
5	БНСУ-ын вон	KRW	1.49	1.27	-0.22	1.35	1.29	-0.06
6	ОХУ-ын рубль	RUB	45.43	45.17	-0.26	46.08	45.56	-0.52
7	Японы иен	JPY	16.03	14.41	-1.62	15.46	14.63	-0.83

Гадаад валютын арилжааны мэдээний нэгтгэлээс үзэхэд тайлант хугацаанд нийт /198,116,862.8₮+188,265,508.3₮/ 386,382,371.1 мянган төгрөг буюу /138,487.1\$+131,377.5\$/ 269,864.6 мянган ам.долларын арилжаа хийсний /87,233,426.9₮+83,352,749.1₮/ 170,586,176.0 мянган төгрөг буюу /60,977.6\$+58,166.1\$/ 119,143.7 мянган ам.доллар нь нийт арилжааны 44.14 хувийг, /9,581,032.5₮+9,612,447.7₮/ 19,193,480.2 мянган төгрөг буюу /6,697.3\$+6,707.9\$/ 13,405.2 мянган ам.долларын евро нь нийт арилжааны 4.96 хувийг, /90,205,713.5₮+84,543,134.5₮/ 174,748,848.0 мянган төгрөг буюу /63,055.3+58,996.8/ 122,052.1 мянган ам.долларын юань нийт арилжааны 45.22 хувийг юань эзэлж байгаа бөгөөд үлдсэн 5.66 хувийг бусад валют эзэлж байна.

Нийт гадаад валютуудын арилжаанд тухайн валютын эзлэх хувь:

/График 9/



2.3 Гадаад валютын арилжаа эрхэлдэг ББСБ-уудын санхүүгийн тайлангийн товч үзүүлэлтийн талаар:

Хорооноос тусгай зөвшөөрөл авсан нийт 233 ББСБ байгаагийн 98 ББСБ буюу 42.1 хувь нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгаагийн дотор 39 ББСБ нь зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг дагнан эрхлэх зөвшөөрөлтэй байна. Тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 52.1 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 52.4 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 49.7 хувийг тус тус эзэлж байна.

Гадаад валютын арилжаа эрхэлдэг ББСБ-уудын 2013 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайлангийн товч үзүүлэлт /мян.төг/:

/Хүснэгт 5/

№	Үндсэн үзүүлэлтүүд	Зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй ББСБ-ууд	Гадаад валютын арилжааны үйл ажиллагааг банк бус санхүүгийн бусад үйл ажиллагаатай давхар эрхлэх зөвшөөрөлтэй ББСБ-ууд	Нийт гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ууд
	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	39	59	98
	ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	16.7%	25.3%	42.1%
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	8,029,948.00	152,446,269.00	160,476,217.00
	ББСБ-ын нийт активт эзлэх хувь	2.6%	49.5%	52.1%
Б	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	7,895,104.15	96,288,509.20	104,183,613.34
	ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь	4.0%	48.5%	52.4%
В	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	6,678,692.37	73,293,757.92	79,972,450.29
	ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь	4.1%	45.5%	49.7%
Г	Нийт орлого	572,389.0	21,145,433.1	21,717,822.1
Д	Нийт зарлага	492,665.5	12,960,465.7	13,453,131.2
Е	Ашиг/алдагдал	79,723.5	8,184,967.4	8,264,690.9

Гадаад валютын арилжааны үйл ажиллагааг банк бус санхүүгийн бусад үйл ажиллагаатай давхар эрхлэх зөвшөөрөлтэй 59 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 25.3 хувийг, тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 49.5 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын

эзэмшигчийн өмчийн 48.5 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 45.5 хувийг тус тус эзэлж байна.

Валютын арилжаа дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 38 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 16.7 хувийг, тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 2.6 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 4.0 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 4.1 хувийг тус тус эзэлж байна.

САНАЛ, ДҮГНЭЛТ

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулдаг ББСБ-уудын /тооны/ судалгааг гаргаж тэдгээрийг энэхүү үйл ажиллагааг банк бус санхүүгийн бусад үйл ажиллагаатай давхар эрхэлдэг эсэх болон дангаар эрхлэн явуулдагаар нь тус тус ангилан холбогдох тоон үзүүлэлтүүдийг хариуцсан хянан шалгагч нартай тулгаж тохируулсан болно.

Нэгтгэлээр тайлант хугацаанд гадаад валютын арилжааны мэдээ ирүүлбэл зохих нийт 98 ББСБ бүгд мэдээгээ ирүүлж мэдээний ирц 100.0 хувь байна. Үүнээс 29 ББСБ үйл ажиллагаа явуулаагүй тухай албан бичгээ ирүүлсэн бөгөөд ирцэд оруулж тооцсон болно.

Мэдээний ирц 2011 оны 1,2,3,4 дүгээр улиралд 54.2% -с 78.8%, 2012 оны 1,2,3,4 дүгээр улиралд 67.0% -с 74.7%, 2013 оны 1 дүгээр улиралд 71,4 хувь, 2013 оны 2 дугаар улиралд 70,4 хувь тай байна. Энэхүү үзүүлэлт нь цаашид гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулдаг ББСБ-уудын үйл ажиллагааг идэвхжүүлэх, мэдээний ирцийг нэмэгдүүлэх улмаар гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй бүх ББСБ-уудаас энэхүү мэдээг сар бүр бүрэн гаргуулж авахын зэрэгцээ түүний үнэн зөв бодитой эсэхэд хяналт тавих шаардлагатай байгааг илтгэж байна. /Гадаад валютын арилжааны мэдээний ирцийн талаарх мэдээллийг ББСБ тус бүрээр гаргаж, танилцуулгад хавсаргав/.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-ууд нь гадаад валютын ханшийн зөрүүн дээр ашиг олох зорилготой байдагтай уялдан ББСБ-уудын мөнгөн хөрөнгө зах зээл дээрх эрэлт хэрэгцээтэй уялдан өдөрт хэдэн ч удаа эргэлтэд орох тохиолдол гардаг. Иймээс гадаад валютын худалдсан болон худалдан авсан мөнгөний дүн өндөр дүнтэй гардаг.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт ББСБ-уудыг арилжааны мэдээгээ сар бүр, бүрэн цахим хэлбэрээр ирүүлж байхыг хариуцсан хянан шалгагч нар нь утсаар ярьж, шаардан цахим болон хэвлэмэл хэлбэрээр авч байна. Цахим хэлбэрээр мэдээгээ ирүүлэх ББСБ-уудыг 2013 оны 2 дугаар улиралд бүрэн хамруулах зорилготой ажилласан бөгөөд үйл ажиллагаа явуулсан ББСБ-уудаас 100 хувь мэдээгээ авсан байна.

Мэдээг цахим хэлбэрээр ирүүлсэн ББСБ-уудын тоог авч үзвэл:

/Хүснэгт 6/

№	Хугацаа	Ирц /ББСБ тоогоор/
1	2011 оны 8 дугаар сар	15
2	2011 оны 9 дүгээр сар	12
3	2011 оны 10 дугаар сар	31
4	2011 оны 11 дүгээр сар	41
5	2011 оны 12 дугаар сар	39
6	2012 оны 1 дүгээр улирал	36
7	2012 оны 2 дугаар улирал	34
8	2012 оны 3 дугаар улирал	31
9	2012 оны 4 дүгээр улирал	69
10	2013 оны 1 дүгээр улирал	70
11	2013 оны 2 дугаар улирал	69

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулдаг ББСБ-ууд нь бэлэн мөнгөөр арилжаа хийдэг учраас гадаад валютын арилжааны мэдээг бүх ББСБ-уудаар сар бүр, бүрэн гаргуулан авч, нэгтгэлд хамруулж байх нь мөнгө санхүүгийн зах зээл дээр эргэлдэж буй бэлэн мөнгөний тоо хэмжээг тодорхой гаргахад чухал ач холбогдолтой.

Мэдээний ирц, үнэн бодит байдал нь мөнгө санхүүгийн зах зээл дээр арилжаалагдаж буй гадаад валютын нэр төрөл түүний тоо хэмжээ, ханш, ханшийн хэлбэлзэлийн талаарх мэдээллийг тодорхой харуулах юм. Энэ нь гадаад валютын ханшийн өөрчлөлтүүд манай улсын үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид хэрхэн нөлөөлж буй эсэхийг тодорхойлоход төдийгүй мөнгөний бодлогод чухал үүрэг гүйцэтгэнэ.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР